



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АЖИЛЫН АНБА**

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН  
ТАНИЛЦУУЛГА**

Шалгалтанд хамрагдсан байгууллага:  
Шалгалтанд хамрагдсан огноо:  
Шалгалт хийсэн байцаагч:

Шивээговь ОНХСан  
2020, 2021 он  
Н.Алтанцэцэг, Э.Цэлмэгбаяр

**2022 он**



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТАНИЛЦУУЛГА

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар ИХА 2022-09/02-17

Сүмбэр сум.

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар хяналт шалгалт хийлээ.

Шалгалтыг "Төрийн хяналт шалгалтын тухай", "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай", "Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай" хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол шийдвэр, заавар, журмын биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор хийж гүйцэтгэв.

Тус сангийн хөрөнгийн зарцуулалт холбогдох хууль журмын дагуу бүрэн хийгдсэн байна. Мэдээллийг УМСанд бүрэн байршуулаагүй байна. Иймд тус сангийн үйл ажиллагааг бага эрсдэлтэй гэж дүгнэв.

**1. ТАНИЛЦУУЛГА**

Тус сангаас 2020 онд 18 ажилд 259,073.2 мянган төгрөг, 2021 онд 28 ажилд 336,477.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллажээ. Шалгалтанд хамрагдсан тайлант хугацаанд төсвийн хөрөнгийн захиран зарцуулах эрхийн нэгдүгээрийг 2020 оны 12 дугаар сар хүртэл С.Ягаанцэцэг, түүнээс хойш П.Ганчимэг, хоёрдугаарыг 2021 оны 12 дугаар сар хүртэл Э.Дөлгөөн, түүнээс хойш Л.Цэнд-Аюуш нар зурж Төрийн сан банкны 100220352400 тоот бүртгэлийн дансаар гүйлгээ хийж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ. Тус сангийн 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн зардлыг Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Сумын 2020 оны төсөв батлах тухай" 11 дүгээр

4202206022

тогтоолоор 314,291.4 мянган төгрөгөөр, 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн зардлыг Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2021 оны төсвийг батлах тухай” 09 дүгээр тогтоолоор 306,510.9 мянган төгрөгөөр тус тус баталсан боловч Сумын ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн “Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолоор 61,213.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 367,724.4 мянган төгрөгөөр баталжээ.

## **ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ**

### **1.1 Шалгалтын зорилго**

Шалгалтыг “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол шийдвэр, заавар, журмын биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор хийж гүйцэтгэв. Тухайн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд шалгалтын зорилго оршсон.

Шалгалтыг аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн баталсан удирдамжаар Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан баланс гаргалтанд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөхөөр Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Н.Алтанцэцэг, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Э.Цэлмэгбаяр нар хийж гүйцэтгэв.

### **1.2 Шалгалтын цар хүрээ**

Тус сангийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

## **2. ШАЛГАЛТЫН ҮР ДҮН**

### **2.1 Илэрсэн асуудлууд:**

**Асуудал 1. 3 дугаар цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг 2021 онд нийлүүлэх ёстой байсан боловч одоог хүртэл гүйцэт нийлүүлээгүй байна.**

**Шалгуур:** 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн Говьсүмбэр аймгийн Шивээговь "Цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж" нийлүүлэх 2021-ШХА-11 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний 2 дугаар зүйлийн 2.1-т "Гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2021 оны 09 дүгээр сарын 27-ныг хүртэл хүчинтэй" гэж заасан байдаг.

**Бодит нөхцөл байдал:** 3 дугаар цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах тухай ажлын гүйцэтгэгчээр "Маммот" ХХК шалгарч 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр 17,200.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Гэтэл гэрээний хугацааг хил гааль дээр ачаа бараа бөөгнөрсөнтэй холбоотойгоор 1 удаа 14 хоногоор сунгах хүсэлт гаргасан боловч нийлүүлсэн тоног төхөөрөмж нь шаардлага хангахгүй байсан тул ажил хүлээн авах комисс засаж сайжруулахаар буцаах шийдвэр гаргажээ. Гэрээний үлдэгдэл санхүүжилт 6,880.0 мянган төгрөгийг одоог хүртэл олгоогүй хэдий ч тухайн компани нь одоог хүртэл тоног төхөөрөмжөө сайжруулж нийлүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

**Шалтгаан:** Холбогдох хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахгүй байна.

**Үр нөлөө:** Дээрх нөхцөл байдлаас үүдэн төсвийн мөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна.

**Асуудал 2. "Алсын 1, 2 дугаар худгийг шинэчлэх, засварлах" ажлыг одоог хүртэл хүлээж аваагүй байна.**

**Шалгуур:** 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Говьсүмбэр аймгийн Шивээговь "Алсын 1, 2 дугаар худгийг шинэчлэх, засварлах" ажлын 2021-ШХА-09 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний 2 дугаар зүйлийн 2.1-т "Гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2021 оны 09 дүгээр сарын 13-ныг хүртэл хүчинтэй" гэж заасан байдаг.

**Бодит нөхцөл байдал:** Алсын 1, 2 дугаар худгийг шинэчлэх, засварлах ажлын гүйцэтгэгчээр "Теч смарт солюшн" ХХК шалгарч 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

19,700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гэтэл гэрээний хугацааг хил гааль болон ачаа тээвэрлэлтээс шалтгаалан 2 удаа 14, 14 хоногоор сунгах хүсэлт гаргасан боловч одоог хүртэл тус ажлыг хүлээж аваагүй байна. Гэрээний үлдэгдэл санхүүжилт 1,970.0 мянган төгрөгийг одоог хүртэл олгоогүй хэдий ч ямар шалтгаанаар тус ажил хийгдэхгүй байгаа нь тодорхойгүй байна.

**Шалтгаан:** Холбогдох хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахгүй байна.

**Үр нөлөө:** Дээрх нөхцөл байдлаас үүдэн төсвийн мөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна.

**Асуудал 3. ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэл дээр УМС-д мэдээллийг бүрэн оруулахгүй байна.**

**Шалгуур:** Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Журам батлах тухай” 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журмын 10 дугаар зүйлийн 10.3.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХСан хариуцсан мэргэжилтэн ОНХСангийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХСангийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ” гэж заасан байдаг.

**Бодит нөхцөл байдал:** Тус сум нь 2021 онд нийт 28 хөтөлбөр, төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 13 хөтөлбөр, төсөл арга хэмжээний 119,502.3 мянган төгрөгийн мэдээллийг УМС-д оруулаагүй байна.

**Шалтгаан:** Холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллахгүй байна.

**Үр нөлөө:** Дээрх нөхцөл байдлаас үүдэн ОНХСангийн үйл ажиллагааны журам гүйцэт хангагдахгүй байна.

### 3.2 Нэгдсэн дүгнэлт

Тус сангийн үйл ажиллагааны мэдээллийг УМС-нд бүрэн байршуулахгүй байна. Мөн хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлд анхааран ажиллах шаардлагатай.

Шалгалтаар нийт 156,402.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүллээ.

**Зөвлөмж:**

- 3.3.1 Санхүүгийн ажилчдын хоорондын ажлын уялдааг сайжруулах
  - 3.3.2 Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгахгүй байх
  - 3.3.3 ОНХСангийн үйл ажиллагааны журмын дагуу УМСанд мэдээллийг бүрэн байршуулж хэвших
  - 3.3.4 Одоог хүртэл хүлээн аваагүй байгаа ажлын гүйцэтгэлд анхраан ажиллаж, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг 2022 оны 12 дугаар сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлэх
  - 3.3.5 Хяналт, шалгалтаар тогтоогдсон төлбөр, зөрчлийг хугацаанд нь барагдуулах
- 3. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР**

НЭГТГЭЛ БИЧСЭН

СХДАА-НЫ ДАРГА,

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ:

Н.АЛТАНЦЭЦЭГ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧ:

Э.ЦЭЛМЭГБАЯР

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГА:

П.ГАНЧИМЭГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН:

Б.АЛТАНСҮХ

НЯГТЛАН БОДОГЧ:

Л.ЦЭНД-АЮУШ